



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 байр, Их суварга 505,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081

Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdig@selenge.gov.mn

Цахим хуудас: www.selenge.gov.mn

2025.01.03 № 01/19

танай _____-ны № _____

**ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Т.ЭНХБАЯР ТАНАА**

Аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг
хангах салбар хорооны 2024 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөний биелэлт болон холбогдох
мэдээллийг хүргүүлэв.

Хавсралт _____ хуудастай.



Н.ЛХАГВАДОРЖ

432500102

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГСДЫН ХҮЙСИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫН ЖИЛИЙН МЭДЭЭ

МАЯГТ-1а

№	Нутгийн захиргааны байгууллага, харьяа дүүрэг/сумдын ЗДТГ	Төрийн албан хаагчид /үндсэн/			Улс төрийн нийт албан тушаалтан		Үүнээс удирдах АТ				Улс төрийн гүйцэтгэх зөвлөх/ туслах/бусад/ албан тушаалтан	
		Нийт	эрэгтэй	эмэгтэй	эр	эм	Засаг дарга		Засаг дарга орлогч		эр	эм
							эр	эм	эр	эм		
1.	СэАймгийн ЗДТГ	97	44	53	2		1		1			
2.	Алтанбулаг	13	3	10	3	2	1			1	2	1
3.	Баруунбүрэн	18	7	11	4		1					
4.	Баянгол	38	12	26	1	4	1			1	11	22
5.	Ерөө	22	8	14	4		1		1		2	
6.	Жавхлант	20	6	14	5	1	1			1	3	0
7.	Зүүнбүрэн	20	8	12	3	1	1		1		1	1
8.	Мандал	68	26	42	9	2	1		1		5	2
9.	Орхон	12	5	7	1	1	1			1	0	0
10.	Орхонтуул	22	12	10	4		1		1		2	
11.	Сант	30	13	17	4	1	1		1		1	1
12.	Сайхан	46	15	31	3	2	1		1			
13.	Сүхбаатар	39	11	28	3	7	1		1		1	7
14.	Хушаат	17	7	10	4		1		1		2	
15.	Хүдэр	34	15	19	2	2	1			1		
16.	Түшиг	22	2	20	1	1	1			1		
17.	Цагааннуур	51	28	23	5	1	1		1		2	1
18.	Шаамар	26	13	13	2	0	1		1			
19.	Нийт аймаг/дүүргийн ЗДТГ	97	44	53	2	0	1	0	1	0	0	0
20.	Нийт сум/хорооны ЗДТГ	489	188	307	58	25	17	0	11	6	32	35
21.	Нийт дүн	593	235	360	60	25	18	0	12	6	32	35

МАЯГТ-16

№	Нутгийн захиргааны байгууллага, харьяа сумдын ЗДТГ	Төрийн албан хаагчид /үндсэн/			Төрийн захиргааны АХ		Үүнээс удирдах АТ				Төрийн захиргааны гүйцэтгэх		Төрийн захиргааны туслах	
		Нийт	эрэгтэй	эмэгтэй	эр	эм	ЗДТГ-ын дарга		Хэлтэс, албадын дарга		эр	эм	эр	эм
							эр	эм	эр	эм				
1.	Аймгийн/нийслэл ЗДТГ	97	44	53	10	32		1	3	2	7	30		
2.	Алтанбулаг	13	3	10	1	5		1			1	5		
3.	Баруунбүрэн	18	7	11	2	6		1			2	5		
4.	Баянгол	38	12	26	12	26	1				12	25		
5.	Ерөө	22	8	14	2	7		1			2	5		
6.	Жавхлант	20	6	14	3	9		1			3	8		
7.	Зүүнбүрэн	20	0	12	1	4		1			1	3		
8.	Мандал	68	26	42	3	20	1			1	2	12		7
9.	Орхон	12	5	7	1	3	0	1		1	1	2		
10.	Орхонтуул	22	12	10	3	4		1		1	3	3		
11.	Сант	30	13	17	6	11	1	1			5	11		
12.	Сайхан	46	15	31	2	32		1		1				2
13.	Сүхбаатар	39	11	28	4	16		1			3	8	1	7
14.	Хушаат	17	7	10	3	6	1		1		2	4		
15.	Хүдэр	34	15	19	3	11	1			3		11	2	
16.	Түшиг	20	2	18	1	9		1			1	9		
17.	Цагааннуур	51	28	23	3	6	1				2	6		
18.	Шаамар	26	13	13	3	4		1			3	3		
	Нийт сум/хорооны ЗДТГ	593	235	360	63	211	6	13	4	9	50	150	3	16
	Нийт дүн	593	235	360	63	211	6	13	4	9	50	150	3	16

МАЯГТ-1в

№	Нутгийн захиргааны байгууллага, харьяа сумдын ЗДТГ	Төрийн албан хаагчид /үндсэн/			Төрийн үйлчилгээний АХ		Үүнээс удирдах АТ		Төрийн үйлчилгээний гүйцэтгэх		Төрийн үйлчилгээний туслах	
		Нийт	эрэгтэй	эмэгтэй	эр	эм	Хэлтэс, албадын дарга		эр	эм	эр	эм
							эр	эм				
1.	Аймгийн/нийслэл ЗДТГ	97	44	53	28	21			1	2	27	19
2.	Алтанбулаг	13	3	10	2	5				2	2	3
3.	Баруунбүрэн	18	7	11	1	5				2	1	3
4.	Баянгол	38	12	26	8	5			8	5	0	0
5	Ерөө	22	8	14	2	7				5	2	2
6	Жавхлант	20	6	14	3	5			0	2	3	3
7	Зүүнбүрэн	20	8	12	6	7					6	7
8	Мандал	68	26	42	14	19			1	11	13	9
9	Орхон	12	5	7	3	2			0	0	0	0
10	Орхонтуул	22	12	10	4	5				4	4	1
11	Сант	30	13	17	4	5			4	5		
12	Сайхан	46	15	31	4	8				3		3
13	Сүхбаатар	39	11	28	4	5			1	1	3	4
14	Хушаат	17	7	10		4				4		
15	Хүдэр	34	15	19	5	8						
16	Түшиг	20	2	18	5	1			5	1		
17	Цагааннуур	51	28	23	7	7			5	7	2	
18	Шаамар	26	13	13	7	7			7	7		
19	Нийт аймаг/дүүргийн ЗДТГ	97	44	53	28	21			1	2	27	19
20	Нийт сум/хорооны ЗДТГ	496	191	307	79	105			32	59	36	54
21	Нийт дүн	593	235	360	107	126			33	61	63	73

**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ХОРООНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙГДСЭН ТАЙЛАН**

№	Бодлогын үндэслэл	Зорилго, зорилт, үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Биелэлт	Хувь
				2023	2024		
1	1.1	Эрүүл идэвхтэй амьдрах тэгш боломж бүрдүүлж “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах	Дундаж наслалтын зөрүү	9,5	9,4	НҮБ-ын хүүхдийн сан, Дэлхийн Зөн ОУБ-ын дэмжлэгтэйгээр Өсвөр үеийнхэнд зориулсан нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний кабинетыг 2023 оны 12 дугаар сард байгуулан 2024 онд эрсдэлт бүлгийн 20 гаруй эрэгтэй хүүхдийг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэн 1400 гаруй өсвөр үеийн хүүхдүүдэд хүрч үйлчлээд байна. Аймгийн хэмжээний 900 гаруй сурагчдад “Стрессээс хэрхэн ангижрах вэ”, “Эрүүл хооллолт – өглөөний цайны ач холбогдол”, “Бэлгийн боловсрол” зэрэг хичээлүүдийг үе шаттайгаар зохион байгуулах ажлыг өрнүүлж байна.	100
2	1.1.7	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх	Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	2185	2500	2022 онд аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетыг байгуулсан ба 2024 онд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний кабинетаар давхардсан тоогоо 2568 иргэнд үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэг 56, идэвхтэй үзлэг 17, гэрийн үзлэг 1 бусад нь өвчний учир хандсан байна. Мөн 4 иргэнд түрүү булчирхайн үрэвслийн хагалгааг оношилгоо, эмчилгээний удирдамжийн дагуу хийж, эмчилгээ хяналтад авч эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах төлөвлөгөөний дагуу ажиллаж байна	100
3	1.2.10	ЕБС-ийн суралцагчдыг хорт зуршил, болзошгүй эрсдэлт зан үйл болон жендэрийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх үйл ажиллагааг эцэг, эх багш сурагчид/ охид, хөвгүүд/-ийн клубээр дамжуулан идэвхжүүлж дэмжих	Арга хэмжээний тоо		5 арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулсан байх	Өсвөр үеийнхэнд “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх” кабинеттай анхны аймаг боллоо. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөрийн санхүүжилтээр “Өсвөр үеийнхэнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх” кабинет шинээр	100

						байгууллаа. Хүүхдийн өөрөө удирдлагын 167 клуб үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 2527 суралцагч хамрагдаж, 330 гаруй багш, ажилтан чиглүүлэн ажиллаж байна Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулийн 800 гаруй сурагчдад “Электрон тамхины хор хөнөөл”, “Жендер ба хүний эрх”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хүчирхийллийг үл тэвчье”, “Илүүдэл жин, таргалалтыг бууруулах”, “Эрүүл зөв хооллолт”, Бэлгийн замаар дамжих халдварт өвчин”, “Эрүүл амьдралын хэв маяг”, Өсвөр нас ба шилжилтийн нас”, “Өсвөр насны сэтгэл зүйн онцлог”, “Амны хөндийн өвчлөл”, “Архи тамхины хэрэглээ” сэдэвт 96 удаагийн сургалт, нөлөөллийн ажилд өсвөр насны 101832 хүүхдүүдийг хамруулан ажиллаж байна.	
4	1.3.3	Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх	Арга хэмжээний тоо	-	5 арга хэмжээ зохион байгуулж, 100 гэр бүлд зөвлөгөө өгсөн байх	“Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн өдөрлөг”, “Жинхэнэ эр хүн, аав хүн”, “Яг өнөөдрөөс гэр бүлдээ”, “Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал”, “Хүүхдийн хөгжил, онцлог, “Хайраар хамгаалья”, “Хүүхэддээ тавих анхаарал” “Мундаг аав ээжийн өөрийгөө дүгнэх хуудас” зэрэг 106 удаагийн сургалт, 4 арга хэмжээ, Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалт, нөлөөллийн ажил, 11 төрлийн томоохон аянуудыг зохион байгуулж, бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн хүүхдэд тавих анхаарал, халамжийг нэмэгдүүлэх, хүчирхийллээс татгалзах, гэр бүлийн боловсрол олгох зорилгоор шүүхээс албадлагын арга хэмжээ авагдсан 12 иргэн, 1,3 гаруй төрийн албан хаагч, 6,4 мянга гаруй ерөхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын суралцагчид, гэр бүлийн модуль сургалтын 27 сургагч багш бэлтгэн тус сургагч багш нар нь 17 сум, 6 тосгоны хэмжээнд 50 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 15313 иргэнийг хамруулсан.	100
5	1.5.2 1.5.13	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг эрчимжүүлж, хүчирхийллэс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх	Арга хэмжээний тоо	-	2 арга хэмжээ зохион байгуулсан байх	Иргэд олон нийтийн жендерийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хэвшмэл ойлголтыг таслан зогсоох зорилгоор “Хамтдаа цэг тавья” нөлөөллийн аян, 3 удаагийн сургалт, “Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй-Шалтаг бүү тооч”	100

						16 хоногийн аян, цахимаар 7 төрлийн постер, 3 видео бэлтгэн 12000 гаруй хүнд хүргүүлэн ажилласан. Жендерт суурилсан хүчирхийллийн шалтгаан нөхцлийг статистик дүн мэдээнд үндэслэн судлахад хүчирхийллийн шалтгаанаар эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн 447 иргэн байгаагаас танил найз нөхдөдөө 211, гэр бүлийн орчинд 98, үл таних хүнд 98, хамаатан садан 28, эцэг эхийн хүчирхийлэл 6, хууль цагдаагийн байгууллагад 1, бусад 5 гэсэн үзүүлэлттэй байна. Судалгаанд үндэслэн "Жендерт суурилсан хүчирхийллийн нөлөө, осол гэмтлийн шалтгаан, урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг арилгах арга хэмжээ"-г иргэдэд таниулах хүрээнд 16 хоногийн аяныг өрнүүлж "Хүчирхийллийн хэлбэрүүд, хүчирхийллээс үүдэлтэй хор уршиг", "Жендерийн эрх тэгш байдал", "Гэр бүлийн хүчирхийлэл, түүнийг арилгах", "Осол гэмтлээс сэргийлэх" зэрэг инфографик, шторкийг бүх шатны байгууллагын цахим хуудаст байршуулснаар 6900 хүн үзэж, 860 таалагдсан сэтгэгдэл, 531 удаа хуваалцсан үр дүнтэй байна. Мөн хүчирхийлэлд өртдөг байж болзошгүй эмэгтэйчүүдийг сургалтад хамруулж, ЕБС, эрүүл мэндийн байгууллагын албан хаагч, ажилчдын дунд жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг "Цагаан тууз" зүүх аяныг амжилттай өрнүүлсэн.	
7	1.5.8	Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардлагатай зарим төсвийг санхүүжүүлэх	Хөрөнгө шийдвэрлэсэн байна	-		Аймгийн хэмжээнд 40 хамтарсан баг 320 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Мандал сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлаас 10,000,000 төгрөг, Хүдэр сум орон нутгийн төсвөөс 11,500,000 төгрөг, Сүхбаатар сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зардлын ангилалд 30,000,000 төгрөг, Сант сумын төсвөөс 3.250.000 төгрөг тус тус батлуулан ажиллаж байна.	100
8	1.1.13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, тэднийг асран харгалзагчдын нийгмийн амьдралд оролцоход тулгарч байгаа саад бэрхшээлд жендерийн шинжилгээ хийж, салбар дундын төлөвлөлт хийж хэрэгжүүлэх	Жендерийн шинжилгээ, бодлого төлөвлөлт хийгдсэн эсэх	-	Шинжилгээ, бодлого төлөвлөлт хийгдсэн байна.	Сэлэнгэ аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Хүнээ дээдэлж-Хамтдаа хөгжье" уриан доор хэрэгжүүлэн хоёрдугаар бүлэгт "Хүний хөгжил"-ийн талаарх бүлгийг тусган:	100

						Боловсролын салбарыг хөгжүүлэх чиглэлээр 10 заалт, Эрүүл мэндийн чиглэлээр 11 заалт, гэр бүл, хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх чиглэлээр 9 заалт, хөдөлмөрийн зах зээл 6 заалт, Монгол хүний удмын санг хамгаалах чиглэлээр 3 заалтуудыг тус тус тусган, хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 5923 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Сайхан сумд 130 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асран хамгаалагч нарт Хүний эрхийн тухай сургалт, сэтгэл заслын үйлчилгээ, эмчийн үзлэг, нэг цонхны үйлчилгээг үзүүлэн ажиллаж тулгамдаж буй асуудлыг шинжлэн судлаж аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган ажиллаж байна.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 16 заалт тусган батлагдах шатанд хэлэлцүүлэн ажиллаж байна.	
9	2.1.5	Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлэх	Жендэрийн мэдрэмжтэй ажлын байр бий болгосон байгууллагын тоо	-	10 Төрийн байгууллага жендэрийн мэдрэмжтэй ажлын байр бий болгосон байна.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах зөвлөмжүүдийг хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн дээрх чиглэлээр 11 удаагийн сургалтыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын шуурхай хуралд агентлагийн дарга нар, сумдын Засаг дарга нарт үүрэг болгож холбогдох журмуудыг танилцуулан ажилласан. Байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж аймгийн хэмжээний 13 байгууллага албан хаагчдын хүүхэд харах өрөө, албан хаагчдын амралтын өрөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлэхэд саадгүй хүртээмжийн тохируулга хийх, ажлыг байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох чиглэлээр зэрэг ажлуудыг үе шаттай хийж хэрэгжүүлж байна.	100
10	4.3.2	Байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хуулийн хэрэгжилт	-		ЖЭТБХТХ-ийн дагуу төрийн бүх шатанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, орон нутгийн бодлого хөтөлбөр, төлөвлөгөө төсөл,	100

			хангагдсан байна.			шийдвэрт жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусган ажиллаж байна.	
11	3.5.5	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайланг Жендэрийн Үндэсний хороонд тайлагнах	Тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна	-	-	Статистик судалгаа мөн 1212.mn платформд 17 тосгон аймгийн ЖЭТБХорооны холбогдох тоон судалгааг шивж оруулсан.ЖЭТБХТХ-ийн дагуу хүсийн тэнцвэрт байдлын судалгааг гаргаж хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.	100
12	3.1.2	Төрийн байгууллагын захиргааны статистик мэдээллийг хүйсээр ангилж гаргах, ашиглах, дүн шинжилгээ хийх, үр дүнг хэрэглэгч, олон нийтэд хүргэх чадавх бүрдүүлэх	Сургалтад хамрагдсан байгууллага, арга хэмжээний тоо	-	Сумдын Засаг даргын Тамгын газруудад сургалт зохион байгуулсан байна	Аймгийн хэмжээнд стстистик тоон мэдээллийг хүйсээр ангилах ажлыг нутгийн захиргааны байгууллагууд хийж гүйцэтгэж байгаа бөгөөд дүн шинжилгээ хийх талаарх холбогдох мэргэжилтнүүд бэлтгэгдээгүй болно.	70
							100

**НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ХОРОО, ЗӨВЛӨЛ,
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ**

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн хороо, зөвлөл, комиссын нэр	Байгуулсан тушаал шийдвэр	Нийт бүрэлдэхүүний тоо	Үүнээс			
				Дарга /тухайн хороо, зөвлөл, комиссын дарга/		Гишүүд	
				Эр	Эм	Эр	Эм
Засаг дарга ахалсан хороо, зөвлөл, комисс							
1	Сант сум ЖЭТБХСхороо	2019.07.09 А/91	9	1	0	4	5
2	Хушаат сум ЖЭТБХСхороо	2020.01.29 А/07	10	1		2	7
3	Түшиг ЖЭТБХСхороо	2022.01.13 А/12	9		1	1	8
4	Нийт		28	2	1	7	20
Засаг даргын орлогч ахласан хороо, зөвлөл, комисс							
1.	АЖЭТБХАСХороо	2023.05.18 А/273	21	1		10	11
2.	Алтанбулаг сумын ЖЭТБХЗөвлөл	2017.12.13 А/135	10		1	1	8
3.	Баянгол сумын ЖЭТБХС хороо	2019.09.30 А/194	9		1	1	8
4	Цагааннуур ЖЭТБХС	2022.01.21 А/11	7	1			6
5	Нийт		47	2	2	12	34
Засаг даргын Тамгын Газрын дарга ахалсан хороо, зөвлөл, комисс							
1	Баруунбүрэн ЖЭТБХЗөвөл	2024.01.02 А/02	9		1	2	6
2	Ерөө ЖЭТБХЗөвөл	2024.01.08 А/03	9		1	3	5
3	Жавхлант ЖЭТБХСХороо	2025.01.08	7		1	2	4
4	Мандал ЖЭТБХСХороо	2024. А/357	5	1		3	2
5	Орхон ЖЭТБХСХороо	2024.01.08 А/03	7		1		6
	Нийт		49	1	4	10	23

ЖЕНДЭРИЙН ДЭД САЛБАР ХОРОО БАЙГУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

№	СУМДЫН НЭРС	ШИЙДВЭРИЙН ОГНОО	ШИЙДВЭРИЙН ДУГААР	ТАЙЛБАР
1	Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар	2023.05.18	A/273	
2	Алтанбулаг сум	2017.12.13	A/13	
3	Сүхбаатар сум	2024.01.10	A/05	
4	Баянгол сум	2019.09.30	A/194	
5	Сант сум	2019.07.09	A/91	
6	Хушаат	2020.01.29	A/07	
7	Түшиг сум	2022/01/13	A/12	
8	Орхон сум	2020/01/29	A/06	
9	Баруунбүрэн	2024.01.02	A/02	
10	Ерөө	2024.01.08	A/03	
11	Жавхлант	2025.01.08		
12	Мандал	2024. 01.16	A/11	
13	Цагааннуур	2022.01.21	A/357	

ЖЕНДЭРИЙН САЛБАР ХОРООНЫ ГИШҮҮДИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

№	Салбар хорооны гишүүний овог нэр	Хүйс	Албан тушаал	“Жендэр ба бодлого төлөвлөлт” анхан шатны сургагч багшийн модулиар сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх	Төрийн албаны удирдах албан тушаалтны жендэрийн цахим сургалтад хамрагдсан эсэх	Утасны дугаар	Цахим хаяг	Чиг үүрэг, хариуцаж буй үйл ажиллагааны хүрээ
1	Д.Хишигбат	эр	АЗДТГ-ын ТЗУХдарга	үгүй	тийм	99142059		
2	Б.Янжлхам	эм	АЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга	үгүй	тийм	99898006		
3	Я.Мөрөн	эр	АЗДТГ-ын ХБТХОБХдарга	үгүй	тийм	99059632		
4	Х.Мөнхжаргал	эм	АЗДТГ-ын СТСХ дарга	үгүй	тийм	99093734		
5	Л.Төгөлдөр	эр	АЗДТГ-ын ХШҮХ-ийн дарга	үгүй	тийм	99074749		
6	Б.Батхуяг	эр	Аймгийн ЦГдарга	үгүй	тийм	91099181		
7	Л.Зоригтбаатар	эр	ХХҮГДарга	үгүй	тийм	99492073		
8	Ж.Од	эм	ЭМГ-ын дарга	тийм	тийм	99043444		
9	Б.Батмөнх	эр	БТСГдарга	үгүй	Тийм	99193421		
10	Ч.Алтантуяа	эм	БШУГдарга	тийм	тийм	99813031		
11	П.Оюун	эм	ХГБХХГдарга	тийм	тийм	99499986		
12	С.Баасанжаргал	эм	СУГ-ын дарга	тийм	тийм	99803311		
13	Д.Гүндэгмаа	эм	Статистикийн хэлтсийн дарга	тийм	тийм			
14	С.Отгонжаргал	эр	НДаатгалын Газрын дарга	үгүй	тийм	99492011		

15	З.Түвшинтөгс	Эр	БОАЖГ-ын дарга	үгүй	тийм	91118244		
16	Б.Мөнхтөр	эр	ХХААГ-ын Дарга	үгүй	тийм	99093285		
17	Б.Ганзориг	эр	ХЭҮК-ийн ахлах мэргэжилтэн	тийм	тийм			
18	Б.Хашбаатар	эр	Сэлэнгэ аймаг дах ХБИХолбооны дарга	үгүй	тийм	99832017		
19	Е.Алтынай	эм	АЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн	үгүй	үгүй	85112818	altynai@selenge.gov.mn	Салбар хорооны нарийн бичгийн дарга

УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАНД ЗОРИУЛСАН ЖЕНДЭРИЙН ЦАХИМ СУРГАЛТАД ХАМРАГДАЛБАН ТУШААЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

№	Удирдах албан тушаалтны овог нэр	Хүйс	Албан тушаал	Удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалтад хамрагдсан эсэх	Сертификатны №	Утасны дугаар	Цахим хаяг
1.							
2.							
3.							
4.							

“ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ЖЕНДЭРИЙН ЦАХИМ СУРГАЛТ”-Д ХАМРАГДСАН АЛБАН ТУШААЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

№	Албан тушаалтны овог нэр	Хүйс	Албан тушаал	Иргэд олон нийтэд зориулсан жендэрийн цахим тестэд хамрагдсан эсэх	Утасны дугаар	Цахим хаяг
1.	Е.Алтынай	эм	АЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн	тийм	85112818	altynai@selenge.gov.mn
2.	Т.Энхтунгалаг	эм	АЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн	тийм	99735785	enkhtungalag@selenge.gov.mn
3.	Т.Мөнхтүвшин	эм	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн байцаагч	тийм	99084574	
4.	Ц.Амаржаргал	эм	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн байцаагч	тийм	99041310	
5.	Г.Баярхүү	эр	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн байцаагч	Тийм	99497383	
6.	Г.Нансалмаа	эм	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн байцаагч	Тийм	88099109	
7.	Р.Энхтуул	эм	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн ахлах мэргэжилтэн	тийм	99051683	

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ХОРООНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ- ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН НЭГТГЭЛ.

№	Зорилт	Заалт	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатандаа	100	70	30	0	Хувь
1	НИЙТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	12	12		11	1			100
		12	12		21	1			100



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

MND.A0005.905.5053



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/273

Сүхбаатар сум


Жендэрийн эрх тэгш байдлыг хангах
аймгийн салбар хороог шинэчлэн байгуулах тухай.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор баталсан Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, Хорооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий Жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогод төсвийн хамт тусгуулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага, арга зүйгээр ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны дарга (Ж.Сайнцог)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/112 тоот захирамжийг хүчингүй болгосугай.



Аймгийн Засаг даргын 2023 оны
05-р сарын 18-ны өдрийн
11273 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн
салбар хорооны бүрэлдэхүүн

Салбар хорооны дарга:

Аймгийн Засаг даргын орлогч

Салбар хорооны дэд дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-
шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Цагдаагийн газрын дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Биеийн тамир, спортын газрын дарга
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
дарга
Соёл, урлагийн газрын дарга
Статистикийн хэлтсийн дарга
Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Сэлэнгэ аймаг дахь Хүний эрхийн комиссын ахлах
мэргэжилтэн
Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
холбооны дарга (Төрийн бус байгууллага)

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Нийгмийн
хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын
асуудал хариуцсан мэргэжилтэн

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2023 оны 05-р сарын 18-ны өдрийн
11293 тоот захирамжийн хоёрдугаар хавсралт

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн
салбар хорооны ажиллах журам
MIOA0005 9055053

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Жендэрийн үндэсний хорооны аймаг дахь жендэрийн салбар хороо /цаашид "салбар хороо" гэх/-ны зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино

1.2. Салбар хороо нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, "Жендэрийн үндэсний хорооны дүрэм"-д заасан бүрэн эрхийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллах Жендэрийн үндэсний хорооны зохион байгуулалтын нэгж юм,

1.3. Салбар хороо нь харьяа нутаг дэвсгэртээ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХТХ), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөгжлийн бодлого, үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэх, төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалтыг хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

ХОЁР. САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Салбар хороог аймгийн Засаг даргын орлогч ахалж, түүний үйл ажиллагааг удирдлагаар хангана.

2.2. Салбар хорооны дарга нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д зааснаар салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталж мөрдүүлнэ

2.3. Салбар хороо нь Аймгийн Засаг даргын тамгын газар, тэдгээрийн харьяа байгууллага, олон нийтийн байгууллагын оролцоог хангасан байх ба аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна

2.4. Салбар хорооны дарга нь аймгийн Засаг даргын орлогч байна, дэд дарга нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга байна

2.5. Салбар хороо нь сумандаа жендэрийн дэд салбар хороодтой байна. Салбар хороо нь дэд салбар хороог мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

2.6. Аймгийн салбар хороо нь 17-21, суманд 7-9 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна

2.7. Салбар хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Салбар хорооны хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хийнэ. Хуралдааныг салбар хорооны дарга удирдана

2.8. Шаардлагатай тохиолдолд салбар хорооны ээлжит бус хуралдааныг салбар хорооны даргын санаачилгаар, эсхүл хорооны гишүүдийн олонхын санаачилгаар зарлан хуралдуулж болно. Гишүүдийн 50-иас дээш хувь нь хуралдаанд ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.9. Салбар хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ

2.10. Салбар хороо хуралдааны дэгээ энэ журамд нийцүүлэн өөрөө тогтооно.

2.11. Салбар хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар салбар хорооны дарга хурлын тэмдэглэл гаргана

2.12. Салбар хорооны хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, дарга хянаж гарын үсэг зурж албажуулна.

ГУРАВ.САЛБАР ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ

3.1. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд:

3.1.1. Орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, шийдвэрт жөндөрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жөндөрийн мэдрэмжтэй болгох;

3.1.2. Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсөлтэй уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.3. Холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг салбар хороодын гишүүн байгууллагуудын жилийн төлөвлөгөөнд шаардагдах төсвийн хамт тусгуулж, тухайн оны эхний улиралд багтаан батлуулан Жөндөрийн үндэсний хороонд хүргүүлэх;

3.1.4. Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.1.5. Бүх шатны Засаг дарга нартай байгуулах гэрээ болон холбогдох төрийн байгууллагуудын удирдлагуудтай хийх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ЖЭТБХТХ, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгах, үр дүнг тооцох;

3.1.6. Төрийн байгууллагын жөндөрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу

гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах, хэрэгжилтийг тайлагнах;

3.1.7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар, чиглэл, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.1.8. Салбар, орон нутгийн байгууллага болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг дэмжих, салбар дундын зохицуулалтыг хангах;

3.1.9. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан холбогдох тайлан мэдээг бэлтгэж, тогтоосон хугацаанд Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх;

3.2. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд:

3.2.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих ажлыг харьяалах байгууллага, орон нутгийн хэмжээнд /сум, хороо/ зохион байгуулах;

3.2.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцоонд суурилсан аргачлалаар хяналт-шинжилгээ үнэлгээг, хууль тогтоомжид заасан хугацаанд хөндлөнгийн үнэлгээг холбогдох ТББ-аар тус тус хийж гүйцэтгүүлэх;

3.1.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт болон тухайн орон нутагт жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ зэрэг хийхэд энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагуудаар гүйцэтгүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.4. Холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх;

3.1.5. Салбар хорооны гишүүдийн жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд ЖЭТБХТХ, холбогдох, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн хамт тусгах, үр дүнг тооцох;

3.3. Жендэр статистик мэдээллийг бүрдүүлэх хүрээнд:

3.3.1. Тухайн орон нутаг, салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх;

3.3.2. Орон нутгийн жендэрийн нөхцөл байдлын статистик мэдээлэл /үзүүлэлт/-ийг бүрдүүлэх, цаашид тус үзүүлэлтүүдийг сайжруулан жил бүр тогтмол гаргаж хэвшүүлэх

3.3.3. Хүйсээр ангилсан статистикийн мэдээлэлд үндэслэн жендэрийн эрх тэгш байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх, үнэлгээнд үндэслэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах;

3.3.4. Хүйсээр ангилсан мэдээллийг эмхэтгэн, хэрэглэгчдэд хүргэх, түүнийг бодлого боловсруулахад ашиглахад чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулах;

3.3.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8, 19.1.9-д заасан тайлан, мэдээг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.4. Жендэрийн сургалт, судалгаа, гэгээрлийн ажлын хүрээнд:

3.4.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай орон нутгийн чадавхыг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэх;

3.4.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой сайн туршлагыг аж ахуйн нэгж байгууллага, олон нийтэд таниулан сурталчлах;

3.4.3. Жендэрийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх гэгээрэл, сурталчилгааны ажлыг хүн амын дунд зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

3.4.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалахад олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллага, олон улсын байгууллага, иргэдийн оролцоог хангаж, үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах;

3.4.5. Жендэрийн үндэсний хорооны цахим хуудаст байрших "Удирдах албан тушаалтнуудад зориулсан жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх жендэрийн цахим сургалт"-д хамрагдаж, гэрчилгээ авах;

3.5. Жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

3.5.1. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээрх холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагаа, чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.5.2. Орон нутгийн түвшинд анхан шатны нэгжүүдэд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтад өртсөн тохиолдолд зөвлөн туслах, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны зардлыг шийдвэрлүүлэх;

3.5.3. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх нэг цэгийн үйлчилгээг үзүүлэхэд төр, Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хамтран ажиллах;

3.5.4.Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд орон нутгийн иргэд, олон нийт залуучууд, зорилтот бүлгийн оролцоог хангах;

3.5.5.Гэр бүл, нийгэм, соёлын харилцаанд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг арилгах, өөрчлөх талаар бүх нийтийн жендэрийн боловсролыг дээшлүүлэх сургалт, гэгээрлийн аяныг өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.5.6.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлогын хүрээнд эрэгтэй эмэгтэй хүний нийгэм, гэр бүлийн харилцаанд үүссэн тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн түр тусгай арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах;

3.6.Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.6.1.Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавжуулах арга хэмжээг орон нутгийн хэмжээнд тогтмол зохион байгуулах, энэ чиглэлээр хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3.6.2.Улс төр, төрийн алба, бизнес, иргэний нийгмийн байгууллагуудтай залуу манлайлагч эмэгтэйчүүдийг бэлтгэх, сургалт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

3.7.Эдийн засгийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.7.1.Тухайн орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, төсөвлөх арга зүйг нэвтрүүлэх;

3.7.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон төрөөс үзүүлж, байгаа бүх төрлийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.7.3.Охид, эмэгтэйчүүд, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ажилтан, албан хаагчид)-ийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, хөнгөлөлттэй зээл, тусламж үзүүлэх хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэх;

3.8.Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд:

3.8.1.ЖЭТБХТХ-ийн 10 дугаар зүйлд заасан төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангаж, төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал, эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай зөвлөмж, дүгнэлтийг гаргаж, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

3.8.2.Төрийн албыг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгохгүй байх, тодорхой салбар, нэгж

дэх хүйсийн тэнцвэргүй байдлыг арилгах арга хэмжээ (түр тусгай арга хэмжээ) авах хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

3.8.3.Төрийн байгууллагын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэрт байдлыг хангуулах, хэрэгжилтийг тайлагнах;

3.9.Хөдөлмөр, эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жөндөрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.9.1.Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жөндөрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жөндөрийн эрх тэгш байдлыг хангах талаар Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйл (Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын 7 дугаар зүйлд заасан дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх)-д заасан ажил олгогчийн үүргийн хэрэгжилтийг харъяа байгууллага, нутаг дэвсгэрийн хүрээнд хангуулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.9.2.Хүүхэд төрүүлэх, хүүхэд асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөж, чадахуйц түвшинд байлгах зорилгоор тэднийг давтан сургалтад хамруулах бодлогыг байгууллага, харъяа агентлаг, нутаг дэвсгэрийн хэмжээнд авч хэрэгжүүлэх;

3.9.3.Ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг хөдөлмөрийн дотоод журамд тусгуулах ажлыг байгууллага, харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;

3.9.4.Байгууллагын түвшинд жөндөрийн мэдрэмжтэй байгууллагын соёл, ажил ар гэр, амьдралын тэнцвэрт байдлыг хангах, гэр бүлийн үүргээ хослуулах, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын уян хатан цагийн зохицуулалтыг хийхэд арга зүйн зөвлөгөө өгөх;

3.10.Соёл, боловсрол дахь жөндөрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.10.1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллага зэрэг зарим байгууллагын ажил, үйлчилгээний онцлогоос хамаарч түр, тусгай арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.10.2.Сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, шалгуур үзүүлэлтэд жөндөрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.10.3.Эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол олгох хичээлийн агуулгыг насны онцлогт тохируулан ЕБС болон албан сургалт, их дээд сургуулийн хөтөлбөрт тусгуулах;

3.11.Эрүүл мэндийн салбар дахь жөндөрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.11.1.Эрэгтэй, эмэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс (эрэгтэй, эмэгтэй)-ийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээг бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах, үйл ажиллагааг тогтвортойгоор дэмжих;

3.11.2.Орон нутгийн алслагдмал нутгийн хүн ам, малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, явуулын эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол хүргэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.11.3.Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн үржихүй болон эрүүл мэндийн чиглэлээр насны онцлогт тохируулан мэдлэг мэдээллийг олгоход дэмжлэг үзүүлэх;

3.12.Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын оролцоог хангах чиглэлээр:

3.12.1.Жөндөрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомж, төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавихад оролцох, хөндлөнгийн хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд энэ чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах;

3.12.2.Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах төрийн байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх;

3.12.3.Жөндөрийн асуудлаар төр, иргэнийн нийгэм, хувийн хэвшил, олон улсын түншлэгчид болон иргэдийн олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх;

ДӨРӨВ.САЛБАР ХОРООНЫ ДАРГА, НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

4.1.Салбар хорооны дарга (дэд дарга) дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1.Салбар хорооны ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг баталж, хуралдааныг товлох, даргалах, хуралдааны тэмдэглэлийг албажуулах;

4.1.2.Салбар хорооны даргын эзгүйд түүний эрх олгосноор дэд дарга салбар хорооны үйл ажиллагааг удирдах;

4.1.3.Гишүүдэд чиг үүргийн дагуу жөндөрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих;

4.1.4.Салбар хороог төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцах;

4.1.5.Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр удирдлагаар хангах, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.1.6.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогод төсвийн хамт тусгуулан батлуулах;

4.1.7.Салбар хорооны тайлан, мэдээллийн бодит байдалд хяналт тавих;

4.1.8.Тухайн харьяалах сум, хороодын дэд салбар хорооны үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих;

4.1.9.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр гишүүдийн чиг үүргийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийн хамт тусгаж, үр дүнг тооцох, дүгнэж, урамшуулах;

4.1.10.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнах, хэлэлцүүлэх, гарсан санал, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;

4.1.11.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээрх арга хэмжээнд зарцуулж буй хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

4.1.12.Гишүүн нь хүлээсэн үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа биелүүлээгүй тохиолдолд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ;

4.1.13.Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын ачаалал, үр дүн, ур чадвартай нь уялдуулан холбогдох хууль, журамд нийцүүлэн дэмжих, урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах;

4.1.14.Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж байгаа аливаа нэгдсэн арга хэмжээнд салбар хороодын гишүүд болон холбогдох удирдлага, албан тушаалтнуудыг оролцуулах;

4.1.15.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр байгууллага, иргэнийг шагналд урамшуулалд тодорхойлох;

4.2.Салбар хорооны нарийн бичгийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар салбар хорооны дарга, гишүүдийг холбогдох мэдээ, мэдээллээр хангах;

4.2.2.Салбар хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, гишүүдээс санал авах, нэгтгэх, салбар хорооны даргаар батлуулах;

4.2.3.Салбар хорооны дарга, гишүүдэд төлөвлөгөөний биелэлт, үр дүнг улирал тутам тайлагнах, дараа улиралд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, танилцуулах;

4.2.4.Салбар хорооны хуралдааны бэлтгэлийг хангах, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, хуралдааны шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

4.2.5.Нарийн бичгийн дарга нь дараах тайланг дэд салбар хороодоос авч нэгтгэн салбар хорооны даргаар албажуулан хууль тогтоомжид заасан хугацаанд Жендэрийн үндэсний хороонд хүргүүлнэ. Үүнд:

4.2.5.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, мэдээ(холбогдох захиргааны маягт, зааврын дагуу);

4.2.5.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн тайлан (бичмэл тайлан);

4.2.5.3.Нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын тайлан;

4.2.5.4.Нутгийн захиргааны байгууллагын дэргэдэх хороо зөвлөл, комиссын төлөөллийн хүйсийн мэдээлэл;

4.2.6.Салбар хорооны хуралдааны тэмдэглэл болон бусад холбогдох тайлан, үйл ажиллагааны талаар архивын нэгж үүсгэн бүрдүүлж, хуульд заасан хугацаанд байгууллагын архивд хүлээлгэн өгнө.

4.3.Салбар хорооны гишүүд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.1.Салбар хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар санал гаргах, хуралдаанаар хэлэлцүүлэх;

4.3.2.Салбар хорооны хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд оролцох;

4.3.3.Салбар хорооны тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг чиг үүргийн дагуу хариуцан зохион байгуулах, гүйцэтгэх, тайлагнах;

4.3.4.Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж байгаа аливаа нэгдсэн арга хэмжээнд оролцох;

4.3.5.Гишүүн нь холбогдох асуудлаар орон нутгийн төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалтыг хангах;

4.3.6.Орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан мэдээллийг бүрдүүлэхэд хариуцсан чиглэлийн дагуу гишүүд холбогдох мэдээ, тайлан, статистик тоо баримтыг үнэн зөв, бодитой гаргаж өгөх;


4.3.7.Салбар хорооны гишүүд нь хэлэлцсэн асуудлаарх гаргасан шийдвэрийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

ТАВ.САЛБАР ХОРООНЫ САНХҮҮЖИЛТ

5.1.Хорооны үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн болон зохион байгуулалтын зардлыг тухайн орон нутгийн Засаг даргын тамгын газар хариуцна

5.2.Салбар хороо нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд жөндөрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний зардлыг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах

5.3.Салбар хорооны гишүүд нь өөрийн хариуцсан чиг үүргийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тус тусын байгууллагын төсөвт суулгаж санхүүжүүлнэ.



ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН
САЛБАР ХОРООНЫ ДАРГА Ж.САЙНЦОГ

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН САЛБАР ХОРООНЫ
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.

№	Бодлогын үндэслэл	Зорилго, зорилт, үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх байгууллага	
						Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	1.1	Эрүүл идэвхтэй амьдрах тэгш боломж бүрдүүлж "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах"	Дундаж наслалтын зөрүү	2023	2024	ЭМГ, БТСГ	АЗДТГ, ЖЭТБХАСХ
2	1.1.7	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх	Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	9,5	8	ЭМГ, АНЭ	АЗДТГ, ЖЭТБХАСХ
3	1.2.10	ЕБС-ийн суралцагчдыг хорт зуршил, болзошгүй эрсдэлт зан үйл болон жендэрийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх үйл ажиллагааг эцэг, эх багш сурагчид/ охид, хөвгүүд/-ийн клубээр дамжуулан идэвхжүүлж дэмжих	Арга хэмжээний тоо	2185	2500	БШУГ, ХГБХХГ	АЗДТГ, ЖЭТБХАСХ
4	1.3.3	Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх	Арга хэмжээний тоо	-	5 арга хэмжээ зохион байгуулж, 100 гэр бүлд	ХГБХХГ, сумдын ИТХ, сумдын ЗДТГ	АЗДТГ, ЖЭТБХАСХ

						зөвлөгөө өгсөн байх			
5	1.5.2 1.5.13	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг эрчимжүүлж, хүчирхийллэс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх	Арга хэмжээний тоо	-	2 арга хэмжээ зохион байгуулсан байх	АЦГ, ХГБХХГ, сумдын ИТХ, сумдын ЗДТГ	АЗДТГ, ЖЭТБХАСХ		
7	1.5.8	Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардлагатай зарим төсвийг санхүүжүүлэх	Хөрөнгө шийдвэрлэсэн байна	-		АЗДТГ, АИТХ, сумдын ЗДТГ, сумдын ИТХ	АЗДТГ, ЖЭТБХАСХ		
8	1.1.13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, тэднийг асран хэргэлзэгчдийн нийгмийн амьдралд оролцоход тулгарч байгаа саад бэрхшээлд жендэрийн шинжилгээ хийж, салбар дундын төлөвлөлт хийж хэрэгжүүлэх	Жендэрийн шинжилгээ, бодлого төлөвлөлт хийгдсэн эсэх	-	Шинжилгээ, бодлого төлөвлөлт хийгдсэн байна.	ХХУГ	АЗДТГ, ЖЭТБХАСХ		
9	2.1.5	Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлэх	Жендэрийн мэдрэмжтэй ажлын байр бий болгосон байгууллагын тоо	-	10 Төрийн байгууллага жендэрийн мэдрэмжтэй ажлын байр бий болгосон байна.	Төрийн байгууллагууд, сумдын ИТХ, сумдын ЗДТГ	АЗДТГ, ЖЭТБХАСХ		
10	4.3.2	Байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	-		Төрийн байгууллагууд, сумдын ИТХ, сумдын ЗДТГ	АЗДТГ, ЖЭТБХАСХ		
11	3.5.5	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайланг Жендэрийн Үндэсний хороонд тайлагнах	Тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна	-		Төрийн байгууллагууд, сумдын ИТХ, сумдын ЗДТГ	АЗДТГ, ЖЭТБХАСХ		
12	3.1.2	Төрийн байгууллагын захиргааны статистик мэдээллийг хүйсээр ангилж гаргах, ашиглах, дүн шинжилгээ хийх,	Сургалтад хамрагдсан байгууллага,	-		Статистикийн хэлтэс	АЗДТГ, ЖЭТБХАСХ		

		ҮР дүнг хэрэглэгч, олон нийтэд хүргэх чадавх бүрдүүлэх	арга хэмжээний тоо	Тамгын газруудад сургалт зохион байгуулсан байна		
--	--	---	-----------------------	---	--	--